0087300016

Reçu CLT / CIH / ITH
Le 08 FEV. 2013
N° 0083

Consent-01-translation

"AS" Calligraphy Center

Letter of support to the submission of the nomination file

January 187, 2013 Ulaanbaatar city

The inscription of the Mongolian Calligraphy in Urgent Safeguarding List of Intangible Cultural Heritage is indeed important for the improvement of national pride of the Mongols and to the contribution of the improvement of the revitalization of traditional culture.

"AS" Calligraphy Center was established back in 1990s with aims to revive, develop and raise the awareness of the tradition of Mongolian Calligraphy not only among Mongolian youth, but also to the world; and started to disseminate through various exhibitions, works of calligraphy, books and publishing. The act of the preparation and submission of the nomination file "Mongolian Calligraphy" is being widely supported and encouraged by various stakeholders including bearers.

It is highly expected and supported activity to disseminate the Mongolian Calligraphy in Mongolia. I, as a calligrapher and a researcher, am highly honoured to be involved and committed in such a deed.

Hereby, I fully encourage and support the activity to submit the nomination file of the Mongolian Calligraphy to the UNESCO List of intangible cultural heritage.

Head of "AS" Calligraphy Center Jalair Do.Batbayar

МОНГОЛ ҮНДЭСНИЙ УЛАМЖЛАЛТ УРЛАГ
**“АС“ УРАН БИЧЛЭГИЙН ТӨВ**
210648 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө
P.O.BOX 2118; Ulaanbaatar- 15160
Tel: 976-99098237
E-mail: batbayar@mongoliancalligraphy.com
http://www.mongoliancalligraphy.com

______________ №______________

UNESCO –ийн биет бус соёлын өвийн төв комисст

Санал

Монгол уран бичлэгийн уламжлалт урлагийг орчин үеийн хүүхэд залуучуудын дунд төдийгүй дэлхийн соёлт улс орнуудад түгээн дэлгэрүүлэх эхлэл санаачлагыг үүсгэн байгуулсан „ АС“ каллиграф төв нь үйл ажиллагаагаа явуулаад 22 жил болж байна. Дэлхийн биет бус соёлын өвд Монгол Уран Бичлэгийг бүртгүүлэх үйл ажиллагааг бахархалтайгаар сайшаан дэмжиж байна.
Энэ нь монголын үндэсний бичгийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх нэр хүндтэй үйл ажиллагаа юм.
Манай хамт олон шавь нар болон монголын ард түмэн UNESCO –ийнүндэсний төвд баярлан талархахын зэрэгцээ бид бүхний санал хүсэлтийг дэмжинэ гэх найдаж байна.

„ АС“ каллиграф төвийн тэргүүн Жалайр До.Батбаяр

Consent-02-translation

**To Mongolian National Commission for UNESCO**

The Mongolian script is world's intellectual heritage, which was being heritage of world nomads over 800 years.

The calligraphy symbolizes identification Mongolian ethnics in the world and shows cultural feature of nomads in Central Asia. We are looking forward, you will offer to registry the Mongolian calligraphy as one of the world intangible cultural heritage.

Defense Science Institute:

| | |
|---|---|
| Sc.D, professor, State Merited Teacher | G.Myagmarjav |
| Sc.D, professor | Sh.Palamdorj |
| Sc.D, professor | Kh.Shagdar |
| Ph.D, professor | S.Ganbold |
| Ph.D, professor | J.Bazarsuren |
| Ph.D, associate professor | T.Erdenekhishig |

Vice Director of Defense Science Institute,
Scientific Secretary, P.D, Professor Colonel G.Myagmarsambuu

**ОЛОН УЛСЫН "ЮНЕСКО"-ИЙН МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ КОМИССТ**

Дэлхийн нүүдэлчдийн өв соёл болж 800 гаруй жилийг туулсан Монгол бичиг бол дэлхийн оюуны өв соёл мөн.

Монгол уран бичлэгийн урлаг бол монгол туургатны бичиг соёлын өвөрмөц нандин дүр төрх гол илэрхийлэл нь юм.

Монгол уран бичлэгийн урлагийг "Дэлхийн биет бус соёлын өвийн санд дэлхийн дахин давтагдашгүй өв соёлын нэг мөн" хэмээн бүртгэн авна гэдэгт итгэлтэй байна.

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН:

Доктор (Sc.D), профессор,
МУ-ын гавьяат багш — Г.Мягмаржав

Доктор (Sc.D), профессор — Ш.Паламдорж

Доктор (Sc.D), профессор — Х.Шагдар

Доктор (Ph.D), профессор — С.Ганболд

Доктор (Ph.D), профессор — Ж.Базарсүрэн

Доктор (Ph.D), дэд профессор — Т.Эрдэнэхишиг

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ОРЛОГЧ ЗАХИРАЛ,
ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР ХУРАНДАА — Г.МЯГМАРСАМБУУ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН
УКД0139

2013.02.05.

Consent-03-translation

Logo: Goethe Universitat

Frankfurt am main

Frankfurt, February 02, 2013

Letter of support to the submission of the nomination file to UNESCO List

Hereby I sincerely support that the need to safeguard the traditional intangible cultural heritage element of the Mongolian Calligraphy is taken into account and being submitted for possible inscription on the Urgent safeguarding list of ICH.

Currently, I study at the Frankfurt city in Germany in the field of linguistics and work at the same sector.

I have become to be tremendously interested in Mongolian Calligraphy since 2007.

Today, there is an inevitable danger for the Mongolian calligraphy to be forgotten due to its limited accessibility and visibility to the general public. Therefore, I sincerely hope if we take urgent measures, there is an opportunity for all of us to protect, develop and transmit the tradition to the next generations.

We hope for your highest consideration and support.

Germany

Sincerely: B.Kherlen Signature Registration number: ChS: 84111760

GOETHE
UNIVERSITÄT
FRANKFURT AM MAIN

Франкфурт, 04.02.2013

ЮНЕСКО-гийн биет бус соёлын өвийн төв коммист

Дэлхийн соёлын биет бус өвд "Монгол уран бичлэг"-ийг бүртгүүлэх үйл ажилгаа явуулж байгаад миний бие маш их баяртай байна.
Би Герман улсын Франкфүрт хотод олон улс, хэл шинжлэлийн чиглэлээр сурдаг ба энэ чиглэлээрээ хэл судлалын тэнхимд ажилладаг. Би энэ мэргэжилээн ашиглан Монгол хэл болон Монгол уран бичигийг гүнзгийрүүлэн гол зорилгоон болгон судалж ирсэн. Тиймээс та бүхний хийж байгаа "Монгол уран бичлэг"-ийг дэлхийд танилцуулах энэ сайхан үйл ажилгааг дэмжиж байгаагаа илэрхийлээд энэ үйлс бүтэх болтугай хэмээн хүсэн ерөөе!

ХБНГермани Улс

Хүндэтгэсэн: Б. Хэрлэн [signature] Регистер ЧС: 84111760

Consent-04-translation

**Consent**

I am studying at “Otoch Maaranba” university by medical science. Traditional old medical books were all written in Old Mongolian Script, so I self studying the Mongolian script in order to better understand these texts. As well as, I have been studying the Mongolian Calligraphy in last few years. I am fully support to inscribe the Mongolian Calligraphy on list of UNESCO. I hope the Mongolian Calligraphy to be listed on UNESCO List of the Intangible Cultural Heritage in Need of Urgent Safeguarding.

S.Gerel-Erdene
ID: 90010201

2013.02.05

Садгэрэн овогтой Гэрэл-Эрдэнэ
РД: 90010201

Зөвшөөрөл

Би "Оточ маарамба" дээд сургуульд уламжлалт анагаах ухаанаар суралцдаг оюутан. Хуучны уламжлалт анагаах ухааны судрууд хуучин Монгол бичиг дээр байдаг учраас би Монгол бичгийг бие даан сонирхон суралцсан юм. Үүний зэрэгцээ Монгол бичгийн уран бичлэгийг сүүлийн жилүүдэд сонирхон суралцаж байна. Уран бичлэгийг ЮНЕСКО-гийн жагсаалтанд бүртгүүлэхийг урьдчилан мэдэж [illegible] зөвшөөрч байгаагаа илэрхийлье.

Уран бичлэгийг ЮНЕСКО-гийн жагсаалтанд бүртгэгдэнэ гэдэгт итгэж найдаж байна

2013.02.05

Consent-05-translation

**To Intergovernmental Committee for the Intangible Cultural Heritage of UNESCO**

Support letter

It is our pleasure to express our full commitment and support in all stages of the activities of the preparation of the Nomination File of the element "Mongolian Calligraphy" on the UNESCO List of Intangible Cultural Heritage in Need of Urgent Safeguarding. After inscribed on list, the "Mongolian Calligraphy" not only Mongolians but also humanity's intellectual cultural heritage to be protected.

Sincerely yours,
Artist O.Khuderchuluun

....................../ID:KG 85111710/

Юнеско-гийн биет бус соёлын өвийн төв комисст

Монгол уран бичиг нь дэлхийн биет бус соёлын өвд бүртгэгдэх нь зайлшгүй уран бичигчийн хувьд болоод нийт Монголчууд бидний чих тавин хараа сунган хүлээж буй бахархал болоод ирээдүйд бидний оюун соёлын дархлаажилт, түгэн дэлгэрэх нэг чухал нөхцөл болох юм.

Та бүхэнд чин сэтгэлийн гүн талархал бичгээр илэрхийлье.

[illegible] [illegible] уран бичгийн зураач О. Хүдэрчулуун

2013 . 2 . 05

[signature]

КГ 85 111710.

Consent-06-translation

To United Nations Educational, Scientific and Cultural Organization (UNESCO)

Support letter

I am one of the bearers of Mongolian Calligraphy and have been studying this ICH element in last 3 years. We, youth generations should have to safeguard and transmit the "Mongolian Calligraphy". In hence that, we fully support to inscribe this heritage to the National List of Intangible Cultural Heritage and list of UNESCO.

Support by member of Mongolian Designer's Association:

Ch.Undrakh (................)

Surname: Chuluunbaatar

Name: Undrakh

ID: KHN 83060262

2013.02.05

ЮНЕСКО-гийн жагсаалтад
бүртгүүлэхийг зөвшөөрч
дэмжих нь:

Миний бие , Монгол бичгийн уран бичлэгийн урлагаар сүүлийн 3 жил сонирхон суралцаж буй өвлөн суралцагч юм. „Монгол бичгийн уран бичлэгийн урлаг"-ийг өвлөн хөгжүүлэх, хамгаалах ажил нь залуу үеийнхэн бидний зайлшгүй үүрэг билээ.

Тиймээс энэ гайхамшигт өвийг яаралтай хамгаалах, СББӨ-ийн Үндэсний жагсаалтад, улмаар ЮНЕСКО-гийн жагсаалтад бүртгүүлэхийг чин сэтгэлээс хүлээн зөвшөөрч, бүрэн дүүрэн дэмжиж байна.

Зөвшөөрч дэмжсэн:
Монголын Дизайнерийн
холбооны гишүүн
Чулуунбаатар овогтой
Ундрах.
/ ЧБ. Undrakh /

2013. 02. 05.

Consent-07-translation

**Request to UNESCO for inscribe the Mongolian Calligraphy**

I am painter, calligrapher N.Bat-Erdene, since 1989 I have been supporting activities of my teacher Jalair Do.Batbayar, which was done for studying, promoting and developing of Mongolian Calligraphy. My teacher was initiated the modern Mongolian Calligraphy.

There are necessary requirements appeared to transmit, bear and safeguard this valuable intangible cultural heritage, because the Mongolian Calligraphy is transmitted from teacher to student by very specific technologies of skills.

Since 1997, I have written name of 20000 people of 55 countries by Mongolian Calligraphy, involved 8 co-organized Calligraphic exhibitions, as well as I have organized 4 private Calligraphic exhibitions.

It is my pleasure to express my full commitment and support in all stages of the activities of the preparation of the Nomination File of the element “Mongolian Calligraphy” on the UNESCO List of Intangible Cultural Heritage in Need of Urgent Safeguarding.

N,Bat-Erdene

Painter, artist and director of company “Sakhius-Erdene”

SAKHIUS
ERDENE

2013 оны 2 дугаар сарын 5 № 13/001 Улаанбаатар хот

**ЮНЕСКО-ИЙН БИЕТ БУС СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ КОМИССТ**

Монголчууд бид бичиг соёл, эрдэм боловсролын арвин их өв уламжлал, түүхтэй орон билээ. Тэр дундаа бичиг үсгийн урлаг нь хүн төрөлхтөний соёлд оруулсан үнэтэй хувь нэмэр бөгөөд эдүгээ цагт хөгжлийнхөө шинэ үе шатанд дэвшин гарч, урлагийн гайхалтай өвөрмөц төрөл болон хөгжиж байна.

Зураач, уран бичээч Н.Бат-Эрдэнэ миний бие Монголын орчин цагийн уран бичлэгийг үндэслэгч Жалайр До.Батбаярын шавь бөгөөд 1989 оноос өдгөөг хүртэл багшийнхаа явуулж буй үйл ажиллагаа, судалгааг дэмжиж байдаг билээ.

"Сахиус-Эрдэнэ" ХХК нь монгол уран бичлэгийн урлагийг өөрийн орны болоод дэлхийн олон нийтэд таниулан сурталчлах, бодит хэрэглээнд оруулах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг. Монгол уран бичлэг, урлаг үсгийн төрлөөр дагнан бүтээлээ туурвиж, орчин үеийн хүмүүсийн хэрэгцээ, таашаалд нийцсэн цогц бүтээгдэхүүнээр нийгэмд үйлчилж байдаг байгууллага юм.

1997 оноос одоог хүртэл 55 орны хорь гаруй мянган хүний нэрийг монгол уран бичлэгээр бичиж, хамтарсан 8 үзэсгэлэн, бие даасан 4 үзэсгэлэн гаргаж монгол бичиг үсгээ сурталчилсан.

Монгол уран бичлэгийн урлагийн нарийн нандин, өвөрмөц хэв маяг, дахин давтагдашгүй онцлогийг сурч, судлан хөгжүүлж хойч үедээ өвлүүлэн, улс орныхоо соёлын өнгө төрх, ард олныхоо хэрэгцээ, шаардлагад тохирсон чанартай бүтээл гаргах нь бидний зорилго бөгөөд соёлт хүн төрөлхтөний оюуны сан хөмрөгт энэ чухал үнэт өв, зайлшгүй хадгалагдан үлдэж, цаашид улам боловсрон хөгжих учиртай гэж бодож байна.

Монгол уран бичлэгийн урлагийг дэлхийн оюуны биет бус соёлын өв хэмээн бүртгэж авна гэдэгт ЮНЕСКО-гийн биет бус соёлын өвийн төв комисст гүнээ итгэн найдаж байгаагаа илэрхийлье.

"САХИУС-ЭРДЭНЭ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ
ЗУРААЧ, УРАН БИЧЭЭЧ Н.БАТ-ЭРДЭНЭ

P.O.BOX: 1251/21, ULAANBAATAR, MONGOLIA | E-MAIL: SEAS@MAIL.MN | TEL: +976-99262568

Consent-08-translation

Support letter to UNESCO

MONGOLSOCIETY

The Mongol Society NGO, we are, painter, artists Jalair Do.Batbayar, B.Khishigsuren and N.Bat-Erdene support to inscribe the Mongolian Calligraphy on the UNESCO List of Intangible Cultural Heritage in Need of Urgent Safeguarding.

The Mongol Society NGO was founded in 2009. We are very glad to collaborating with ICH bearers, folk artists and craftsman on promotion, dissemination, transmission and safeguarding of Mongolian cultural heritage.

The Mongol Society NGO, we are fully we fully support to inscribe this heritage to the National List of Intangible Cultural Heritage and list of UNESCO.

Member of Representative Board Council S.Narankhuu

MONGOLSOCIETY
МОНГОЛ НИЙГЭМЛЭГ
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

ДЭЛХИЙН БИЕТ БУС СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ГАЗАРТ

Улаанбаатар хот

2013.01.11

Монгол үндэсний минь утга соёлын илэрхийлэл болсон Монгол уран бичлэгийг дэлхийн биет бус соёлын өвд бүртгүүлэх санаачлагыг манай МОНГОЛ НИЙГЭМЛЭГ төрийн бус байгууллага нь уран бичээч Жалайр До.Батбаяр, Б.Хишигсүрэн, Н.Бат-Эрдэнэ нарын дэмжлэгтэйгээр гаргаж байна.

МОНГОЛ НИЙГЭМЛЭГ ТББ нь 2009 онд үйл ажиллагаа эхэлсэн. Өвөг дээдсийнхээ үлдээсэн өв соёл, түүхээ судлан тогтоож, хамгаалан хөгжүүлэх, сурталчилах, түгээн дэлгэрүүлэх шаардлага энэ цаг үеийн хүндтэй үүрэг хэмээн үзэж соёлын өвийг тээгч, ардын авъяастан, гар урлаач нартайгаа хамтран ажилладагтаа баяртай байдаг билээ.

Дэлхийн соёлын өвийг хамгаалах газрын хамт олон та бүхэндээ Монголын бүх ард түмэн болон МОНГОЛ НИЙГЭМЛЭГ ТББ-ын өмнөөс есөн цагаан хүсэл тань бүтэх болтугай хэмээн хүсэн ерөөе!

Сайн үйлс дэлгэрэх болтугай!

ТУЗ-ийн гишүүн С.Наранхүү

MONGOLSOCIETY
МОНГОЛ НИЙГЭМЛЭГ ТББ
8011869 УЛААНБААТАР ХОТ ХАК9615

ХАЯГ
Утас: 77333377, Цахим шуудан: info@mongolsociety.net, Вэб: http://www.mongolsociety.net

Consent-09-translation

World friends foundation NGO.

***To: The UNESCO, Committee of the Intangible Cultural Heritage***

*Ref: Submitting an offer*

Nominating the "Mongolian Calligraphy" to the list of Intangible Cultural Heritage in need of Urgent Safeguarding is a valuable contribution to the promotion of Mongolian language and culture.

Mongolian traditional script culture has an rich history and is being studied in different ways nowadays.

This is the period the Mongolian traditional script is being developed as an artistic creation and research in the secondary schools, university of culture and institutes. Therefore, we, Mongolians would like to express our full support on the "Mongolian Calligraphy", being registered in the list of the ICH in need of urgent Safeguarding.

Sincerely

Altan-Uya.S

THE HEAD of World friends foundation NGO

WORLD FRIENDS
foundation NGO

ЮНЕСКОГИЙН БИЕТ БУС
СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ КОМИСCТ

Санал хүргүүлэх тухай

Биет бус соёлын өвийн төлөөлөх жагсаалтын 2013 оны "Яаралтай хамгаалах" шаардлагатай биет бус соёлын өвийн бүртгэлд "Монгол уран бичлэг"-ийг дэвшүүлж буй явдал, монгол хэл соёлыг түгээн дэлгэрүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байна.

Монголын уламжлалт бичиг үсгийн соёл нь арвин баялаг түүхтэй төдийгүй орчин үед ч олон төрөл хэлбэр чиглэлээр судлагдаж байна.

Монгол бичиг нь ерөнхий боловсролын сургууль, соёл урлагийн болон их дээд сургуулиудад судалгаа болон уран бүтээлийн төрлөөр хөгжих цаг үе ирж байна. Энэ үед монголчууд бид биет бус соёлын өвд багтаж байгаа "Монгол уран бичлэг"-ийг итгэл дүүрэн дэмжиж байгаагаа илэрхийлье.

НАЙЗУУДДАА
ДЭЛХИЙН
WORLD FRIENDS foundation NGO
САН ТББ
УЛААНБААТАР ХОТ ГТС0127 ... 1085484

ТЭРГҮҮН С.АЛТАН-УЯА

Mongolian Children's Palace
room # 10
Ulaanbaatar Mongolia

Phone: (976) 91196880
E-mail: s.altanuya@yahoo.com

D:\2013bichigbarımt

Consent-10-translation

TO INTANGIBLE CULTURAL HERITAGE SECTION

The ancient tradition of Mongolian Calligraphy is considered one of our nation's important heritage elements. It is the utmost importance and urgent priority for us to safeguard the calligraphy.

Myself, B.Khishigsuren, was first enrolled to the calligraphy transmission class at Mongolian Youth Palace conducted under Jalair Do. Batbayar in 1989. Since 1992, I have actively started learning and practicing with the art of calligraphy, gradually producing my own works of calligraphy, improving my skills and, as well, contributing to the activities of the dissemination of the traditional art nationwide.

I have actively been involved in the preparation of the nomination file Mongolian Calligraphy to the Urgent safeguarding List of Intangible Cultural Heritage since its primary initiation. Hereby, I also would like to express my full support and commitment in the nomination of the Mongolian Calligraphy to the above mentioned list!

I truly hope that the practice of the Mongolian calligraphy could finally be spared from danger of being lost or its viability become degraded at this critical moment.

Ulaanbaatar city signature and stamp Artist, calligrapher

B.KHISHIGSUREN
75041319

04.02.2013

Registration number: ChG:

http://www.khishig-art.com

UNESCO БИЕТ БУС СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ-д

Манай гаригын соёлт ард түмнүүд олон мянган жилийн түүх соёлын үнэт өвөө уламжилан хадагалж, хөгжүүлэн дэлгэрүүлсээр өнөө бидний цаг үеэд иржээ. Гэвч цаг цагаараа байдаггүй цахилдаг хөхөөрөө үлддэггүй гэж Монголчууд бидний хэлэлцдэг үг байдаг. Энэ л учир шалтгааны улмаас мандаж буурдаг ертөнц дээр он цагийн салхинд хийсэн одох соёл суртал, зан үйл, хэв ёсоо мартагдан устах аюулаас сэргийлэж, судалж сурч, түгээн дэлгэрүүлэх нь дэлхийн бүх үндэстний хүсэл зорилго болох ажээ.

Хүн төрөлхтөний утга соёлын давтагдашгүй гайхамшигт илэрхийлэл болсон бичгийн соёл түүн дундаа Уран бичлэгийн урлаг нь үндэстний билиг оюуны өвөрмөц содон байдлыг илүү тодоор тусган харуулдагаараа нэн үнэт чухаг төрөлд багтдаг.

Монголчууд бидний мянга гаруй жилийн тэртээгээс уламжилан хэрэглэж ирсэн Монгол бичиг соёлын чухал хэсэг болох УРАН БИЧЛЭГ нь өнөө цагт дахин сэргээж, ард түмнийхээ билгийн мэлмийг нээх их үйлд өчүүхэн бичээч миний бие, бие сэтгэлээрээн оролцох хувь тохиосонд чин сэтгэлийн гүнээс баярлан явдаг билээ.

Миний бие Баасан овогтой Хишигсүрэн Улаанбаатар хотод 1975 онд төрж.

1988 онд Монголын Хүүхдийн Ордоны уран зургийн дугуйланд Уран бичээч зураач Жалайр До. Батбаяр багшын урланд орж суралцсан.

1992-1996 онд Дүрслэх урлагийн дээд сургуулийн Монгол зургийн ангид Ардын зураач Д.Амгалан багшын урланд суралцан зураач мэргэжилээр дүүргэсэн.

2002-2009 онд Холбооны Бүгд Найрамдах Германи улсын Халлэ хотын урлагийн дээд сургуульд Про.Док Кристина Трипшийн урланд шилэн урлаг, график дэзайнэр мэргэжилээр төгссөн.

1992 оноос хойш Монгол Уран бичлэгт суралцаж өнөөг хүртэл уламжилалт арга барил болон модерн контэнпэриор чиглэлээр цаас, бэх, мод, чулуу, даавуу, шил, будаг ашиглан бүтээлээ туурвиж байна.

Дэлхийн биет бус соёлын өвийг бүртгэх газраас зохион байгуулж буй энэ хүү буянтай үйл хэрэг цаашид улам өрөгжиж, манай гаригын олон үндэстэн нарын өв соёл улам хөгжин дэлгэрэх болтугай! хэмээн даган баясаж уг бичгийг үйлдлээ.

Улаанбаатар хот
Баасан.ХИШИГСҮРЭН зураач, уран бичээч

04.02.2013
Регистер ЧГ: 75041319

http://www.khishig-art.com/

Consent-11-translation

## THE HEAD of Mongolian Children's Palace

*To: The Intergovernmental Committee of the Safeguarding Intangible Cultural Heritage, UNESCO*

*Ref: Registering of Cultural Heritage*

We are, all Mongolians supporting deeply the nomination of the "Mongolian Calligraphy" to the list of Intangible Cultural Heritage in need of Urgent Safeguarding which is an honorable action to recognize and promote the Mongolian Calligraphy to the script culture of humanity throughout the world.

It is an auspicious time for Mongolian youths and descendants to learn and research the Mongolian Calligraphy.

We do hope the process would be successful registering the Mongolian Script to the list of World Intangible Cultural Heritage.

Sincerely,

Ankh-tuya.P

THE HEAD of Mongolian Children's Palace

**МОНГОЛЫН ХҮҮХДИЙН ОРДОН**
210648 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө
Утас/Факс: 976-11-324603

2013.02.05 № 31
танай ______________ -ны № ______________-т

ЮНЕСКОГИЙН БИЕТ БУС
СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ КОМИССТ

Соёлын өвийг бүртгүүлэх тухай

Монголын яаралтай хамгаалах шаардлагатай биет бус соёлын өвийн жагсаалтанд нэр дэвшиж байгаа "Монгол уран бичлэг"-ийг дэлхий дахинд танин мэдүүлэх, хүн төрөлхтөний бичиг үсгийн урлагт монгол бичгийг дэлгэрүүлэн сурталчлах нэр хүндтэй үйл ажиллагааг монголчууд бид бүхэн туйлын баяртайгаар дэмжиж байна.

Монголын хүүхэд залуучууд хойч үе үндэсний бичиг, монгол уран бичлэгийг сурч судлах сайхан цаг үе ирж байна.

Монгол уран бичлэгийг дэлхийн соёлын өвд бүртгүүлэх ажил бүтэмжтэй байна гэдэгт гүнээ итгэлтэй байна.

ЗАХИРАЛ: П.АНХТУЯА

D:\2013\bichig\ant\mt

Consent-12-translation

**To Intergovernmental Committee for the Intangible Cultural Heritage of UNESCO**

Support letter

The newspaper “Khumuun bichig” has been published for 21 years in Mongolian script and gave great contribution for studying, transmitting, promoting the Mongolian script to the public. We are fully support to inscribe the Mongolian Calligraphy on list of UNESCO.

We understand that this nomination process is one of the important activities to promote and transmit the Mongolian script to whole world.

We, Mongolian Script Association, readers of our newspaper are hope that, the Mongolian calligraphy could be inscribed on list of UNESCO, successfully.

Newspaper editor...................B.Elbegzaya

: 329486

2013 02 07

А/: 05

**Соёлын биет бус өвийг хамгаалах Засгийн газар хоорондын хороонд**

Үндэсний монгол бичгийг сургах, судлах, түгээн дэлгэрүүлэх үйлсэд хувь нэмэр оруулж, 21 дэх жилдээ тасралтгүй гарч буй, монгол бичгээр хэвлэгддэг үндэсний хэмжээний, цорын ганц тогтмол хэвлэл "Хүмүүн бичиг" сонины хамт олон дэлхийн биет бус соёлын өвд "Монгол уран бичлэг"-ийг бүртгүүлэх үйл ажиллагааг сайшаан дэмжиж байна.

Энэхүү үйлс нь монгол бичгийг дэлхий дахинд танин мэдүүлэх, хүн төрөлхтөнд дэлгэрүүлэх нэр хүндтэй үйл ажиллагаа хэмээн бид ойлгож туйлын баяртай байна.

"Монгол уран бичлэг"-ийг дэлхийн өвд бүртгэх ажил бүтэмжтэй сайхан болно хэмээн Монгол бичгийн нийгэмлэг, монголын бичиг соёлын зүтгэлтнүүд, манай сонины нийт уншигчид гүнээ итгэж байна.

УХЖ 0063

Сонины эрхлэгч .................................................. Б. Элбэгзаяа

[illegible] :329486
010 [illegible]
[illegible]

« [illegible] »
[illegible]

A/05

07
2
2013

[illegible]

[illegible]

[illegible] UX 0063 [illegible]

# MONGOLIAN ACADEMY OF CULTURE AND POETRY

2013.4.16 №3/12

P.O.Box 998 Ulaanbaatar 14201 Mongolia
Tel/Fax: 976-11-331208
Mobile: 976-99118192
976-99296481
Emails: info@poetry-culture.mn
mendooyo@gmail.com
Web site: www.muzo.mn

To:
**The International Convention for the Safeguarding of the Intangible Cultural Heritage:**

In 2006, the Mongolian Academy for Poetry and Culture organised an important exhibition entitled "Poetry and Script Culture," which ran concurrently with the conference of the World Congress of Poets, and every year since then we have staged exhibitions, which have resulted in two catalogs of calligraphic art.

Mongolian script cultureis a most valuable intellectual treasure with an especial heritage, intimately connected with poetry and the written word. Since the 1940s, the traditional Mongolian script has languished in a stagnant form, and it is only recently that it has been undergoing a reawakening.

We deeply hope that the International Convention for the Safeguarding of the Intangible Cultural Heritage will register the Mongolian Calligraphy as an Intangible Cultural Heritage.

Sincerely,

G.Mend-Ooyo
Poet
President, Mongolian Academy of Culture and Poetry

Retention (Permanent, 10 years)

Consent-13-translation


# СОЁЛ ЯРУУ НАЙРГИЙН АКАДЕМИ

2013.01.06 №3/13 P.O.Box 998 Ulaanbaatar 14201 Mongolia
Tel/Fax: 976-11-331208
Mobile: 976-99118192 / 976-99296481
Email: info@poetry-culture.mn / mendooyo@gmail.com
Web: www.muzo.mn / Blog: www.mend-ooyo.blogspot.com


**ЮНЕСКОГИЙН БИЕТ БУС СОЁЛЫН ӨВИЙН КОМИССТ**

Монголын Соёл, Яруу найргийн Академи нь 2006 онд Монгол улсад зохион байгуулагдсан Дэлхийн яруу найрагчдын их хурлын үеэр "Яруу найраг ба уран бичлэг" хэмээх томоохон үзэсгэлэн гаргасан бөгөөд түүнээс хойш жил болгон тогтмол үзэсгэлэн гаргаж, хоёр удаа каллигарфийн каталог хэвлүүлсэн билээ.

Монгол уран бичлэг нь оюун билгийн үнэт эрдэнэс болох яруу найраг, үндэсний бичиг үсэгтэй салшгүй хөгжиж ирсэн түүхэн онцлогтой. Монгол бичгийг 1940-өөд оноос хойш халсан он жилүүдэд уран бичлэг зогсонги байдалд орсон ч сүүлийн жилүүдэд эрчимтэй сэргэж байна.

Монгол Уран бичлэгийг Юнескогийн биет бус соёлын өвөөр бүртгэх санаачилгыг дэмжиж өгөхийг гүнээ хүсэн, итгэл тавьж байна

Соёл Яруу Найргийн Академийн Ерөнхийлөгч Г.МЭНД-ООЁО